

“Гурван төрөлхтөн”-ий тухай буддын сургаал, орчин үе


Д.Эрдэнэцэцэг – доктор (Ph.D) Орхон аймаг. Хангайн бүсийн УТБА-ийн захирал

Түлхүүр үг : Гурван төрөлхтөн, мөр, мөрийн сургаал, бодь сэтгэл, барамид, савын гурван гэм, сонсохын гурван алдаа

Манай улсад боловсролын үнэ цэнэ унаж, үр ашиг, чанар буурч байгаа хямралт байдлыг бүх хүнийг тэгшлэн сургадаг технологитой холбон үзэх нь зүйтэй. Энэ талаар Д.Ванчигсүрэн... Бүхнийг тэгшлэн сургадаг өнөөгийн эрчимгүй технологийг арга билгийн ухаан, хувь тохирол, амьдралын жамыг зохицуулан үздэг төв ёсны болон энэрэнгүй үзэлд нийцсэн шинэлэг технологиор сольж, хүн бүрийг гарваль шинж (генэтип) төрөлхийн онцлогт тохирсон сургалтанд хамруулан, боловсрол- мэргэжил эзэмшүүлэх замаар монголын уламжлалт “савыг” үзэн сургадаг авч гээхийн ухааныг мөрдлөг болгодог арга- билгийн зохиролт философийг технологийн шинэчлэл хийх үндэс¹⁰⁵ гэж үзсэнд тулгуурлан буддизмын сургаалыг дэлгэрүүлэн судлах зорилго тавилаа.

Уг сургаалд ертөнц бүхэлдээ, түүний дотроос хүн, түүний амьдрал, дотоод ертөнц тэр чигээрээ хүнээс өөрөөс нь үл шалтгаалах объектив хуультай; шалтгаан үрийн холбоогоор холбогдоно; бурханы шашны онолд тэрхүү холбоог үйл- үрийн холбоо хэмээнэ; түүний хүчээр ертөнц дээрх юм бүхэн нэн нарийн эмх цэгц, бүтэц зохион байгуулалттай; эсрэг тэсрэг талууд нь өөр хоорондоо шүтэн барилдсан, барилдлагаар тэрхүү эмх цэгц, зохион байгуулалт нь пирамидын хэлбэр тогтолцоотойгоор оршин тогтоно. Энэхүү тогтолцооны үүднээс буддын сургаал нь дараах байдлаар ангилагддаг.

(Зураг №1-ээр ухаарал, гэгээрлийн ахиц шатыг харуулав)



Зураг №1

Винай буюу сурган хүмүүжлийн ухаан

¹⁰⁵ Монголын дээд боловсрол: XXI зууны үзэл баримтлал (Эрдэм шинжилгээний бага хурал)УБ.,1999.98 дахь тал

Бурханы ном, ухаанд шавь нар нь өөр өөрсдийнхөө оюун ухааны, аливааг ойлгож сэтгэн бодох чадварын хэрээр, түүнд тохируулан, а) бага төрөлхтөн, б) дунд төрөлхтөн, в) дээд төрөлхтөн гэсэн гурван өөр түвшинд суралцах зүй тогтолын дагуу бага төрөлхтний номоо Шравакийн сургаал, дунд төрөлхтний номоо Пратьекабуддын сургаал, дээд төрөлхтний номоо Буддагийн сургаал хэмээн томъёолжээ; эхний хоёр нь (шравака, пратьекабуддын сургаал) нийлээд бага хөлгөн буюу Хинаяна, сүүлийнх нь дангаараа (Буддагийн сургаал) их хөлгөн буюу Махаяна гэдэг. Буддын сурган нь хутагтын дөрвөн үнэнд бие даан багтахгүй боловч тэрхүү дөрвөн үнэний сургаалыг сурч эзэмших эрдэм ухаан нь болдогоороо онцлогтой. Буддын сурган хүмүүжүүлэх ухаан (винай)-д шавь нарын сэтгэн бодох, ухааран ойлгох чадварын түвшингээс хамааруулан нарийн ангилан үзсэн байдаг. (Зураг №2)

I - Аливааг ухаарах, ойлгох

бага түвшний чадвартай цөөн тооны

хүмүүс буюу бага төрөлхтөн

II - Аливааг ухаарах, сэтгэн бодож,

ойлгох чадварын хувьд ердийн, жирийн

түвшинд байх хүмүүс, дийлэнх

олонх буюу дунд төрөлхтнүүд


III-Аливааг ухаарах, гэгээрэх, сэтгэн

бодох чадварын хувьд гоц, дээд

түвшний цөөн тооны хүмүүс буюу дээд

төрөлхтнүүд

оо, давтамж



Нэн дээд төрөлхтөн

Дээд төрөлхтөн

Дунд төрөлхтөн

Бага төрөлхтөн

Дорд төрөлхтөн

Гурван төрөлхтөн хэмээх бол хүнийг гэгээрүүлэхтэй холбоо бүхий ойлголт бөгөөд хүмүүсийн сэтгэхүйн онцлогт тохируулан дэс дараалалтай ухамсарлуулах гэсэн тодорхой арга, байр суурь юм¹⁰⁶. Буддизмд хүний гэгээрхүйн мөрийг нийгмийн амьдралын тодорхой хэв маягтай холбоон, шат дараалалтай гүйцэтгэх журам болгосноор нийгмийн тодорхой үзэл баримтлал болж чаджээ. Буддын философид хүний сэтгэл өөрчлөгдөн хувирагч ертөнцтэй

¹⁰⁶ Гүн ухаан /удиртгал/. УБ., 1999, 171 дэх тал

байнга зөрчилдөж амарлин, тайванг эрэлхийлэн зовж байдаг бөгөөд тэрхүү амарлинг олж болно. Үүний тулд сэтгэлийг өөрчлөх хэрэгтэй. Сэтгэлийг өөрчилж чанарын шинэ төлөвт шилжүүлэх үйл ажиллагааг “мер”¹⁰⁷ гэдэг байна.

Мөрийн сургаал нь хүмүүсийн бие-сэтгэл-ухамсрын доод төлөв байдлаас дээд төлөвт шилжих явцыг номлодог. Уг үзэл баримтлал ёсоор хүнийг гэгээрүүлэх үндсэн арга бол оюуны чадавхитай холбоотой гэж үзээд хүний оюуны хөгжлийн шинж төлөв, мэдлэг чадварын хандлага зэрэг сэтгэлзүйн онцлогоор гурван зэрэг болгон хувааж тус бүрт нь тохирсон хөтөлбөр боловсруулжээ. Аливаа хүний сайн сайхныг хүсэхүй, амгалан ёсыг эрэхүй мөр нь адил боловч түүнийг хэрэгжүүлэх арга, оюун билгийн онцлогоор тэгш бус учир онол суртахууны баримтлалыг ухааруулахад шат дараалсан мэдлэг олгох зорилгоос үүдэлтэй. “Төрөлхтөн өчүүхэн /бага мэдлэгтэн/ нь энэ насандаа тухайлсан гайхамшгийг эс үйлдэх бөгөөд хойд насны өндөр язгууртан хотол төгссөнийг тусгайлан эрэх бөгөөд түүний шалтгааныг бүтээхүй дор орохын тул болой”, “төрөлхтөн дунд хэмээх нь хамаг сансраас гэтэлсэн гэгээрэхүйг өөрийн тусад олгогдхуун болгогч болой”, “төрөлхтөн дээд нь нигүүлсэхүйн эрхээр бусдын эрхэнд болсон тул амьтны зовлон хамаг бүгдийг баран үйлдэхүй тул бурхныг олгогдхуун болгодог болой”¹⁰⁸ гэжээ.

Энэ талаар гүн ухааны сурах бичигт тайлбарлахдаа: “Өчүүхэн төрөлхтөн нь зөвхөн ертөнцийн амгаланг эрэгчид, дунд төрөлхтөн нь амьдрал бол зовлон жаргал болохыг ухаарч зовлонгоос хагацах мөрийг ухаарагчид мөн боловч зөвхөн өөрийн тусын тулд үйлчлэгчид, дээд төрөлхтөн нь бусдад тус болж мөрийг гэгээрэхэд нигүүлсэхүйн сэтгэлээр хандагчид” хэмээн тодорхойлсон байдаг. Иймээс бурхны шашны сургаалыг ухаарах нь гэгээрэхүйн үндэс бөгөөд номын ёсонд суралцахдаа шат дараалалтай багаас их мэдлэг рүү шилжих замаар явагдах ёстойг арга зүйн үүднээс боловсруулсантай гүн гүнзгий танилцах бололцоо олгодог.

Өчүүхэн төрөлхтөн буюу бага мэдлэгтэн хүний хэв маягт ертөнцөд хүмүүн болон төрж, хүний аж төрөхийн жам ёсонд татагдан орж орчлонгийн жаргал зовлонг бие сэтгэлээрээ амсан, амьдралын эрээн барааныг өөрийн оюун сэтгэмжээр цэгнэж, өдөр тутмын амьдралдаа сэтгэл нь ханаж “орчлонгийн амгалан төдийнхнийг” эрхэмлэгч юм. Ийм хэв маягийн хүнд нөлөөлөх, амьдралын идэвхтэй байр суурьт татан оруулах үндсийг сэтгэл зүйн тал хэмээн үзэж, чин сүжиглэл үүсгэх замаар авралын өргөн замд орж, өөрийгөө гэгээрүүлэх замаар хүмүүнлэг ёсыг тогтоох явдал хэмээн үзжээ.

Дунд төрөлхтөн гэдэг нь орчлонгийн амьдрал зөвхөн зовлон болохыг ухаарч, түүнийг давах арга замыг эзэмших замаар өөрийгөө аврах мөрийг хүсэгч хүний хэв маяг. Тэдний мэдвэл зохих үндсийг “сэтгэл судлах” хэмээн үзээд, түүнийгээ зовлонг төрүүлэгчийн үндсийг мэдэх, шүтэн барилдахуйн шалтгааныг мэдэх хэмээн ялгавартайгаар авч үзээд орчлонгийн хотол төгс зовлонг жаргал хэмээн алжаан эндүүрэх учир зовлонгийн олон талыг зовлон үнэн, зовлонгийн шалтгаан үнэн, зовлонг гэтлэх нь үнэн, зовлонг арилгах мөр үнэн хэмээн үзэж, түүний учир шалтгааныг нарийвчлан зүй тогтлыг нь сайтар тайлбарласан байдаг.

Зовлон хэмээхийг бүхний үндэс хэмээн үзээгүй, харин зовлонг мөнх хэмээн мөнхөд баримтлах, зовлон ерөөс үгүй хэмээн тасархайд баримтлах үзлийг няцаан, зовлон бол хүний амьдралын байнгын хөдөлгөөний орчинд бие, хэл, сэтгэхүйн үйлээр мөнх ч биш, мөнхгүй ч биш, тэр хоёрын шүтэлцээн дунд илрэх үзэгдэл хэмээн үзсэн.

Тэгэхээр амьдрал бол дан зовлон биш, дан жаргал биш, энэ хоёрын

¹⁰⁷ Эрх чөлөө ба философи. I. УБ., 1998. 33 дах тал

¹⁰⁸ Адиша. Бодь мөрийн зул. М.Д.183 боть, 3 дээд

харилцаанд оршино гээд зовлонгийн шалтгааныг танин, түүнээс гэтэлсэн нь билигт хүрэхийн сурвалж мөн гэжээ. Зовлонг ийнхүү илэрхийлэхдээ нэг талыг туйлшруулалгүй, түүний нөгөө тал болох “жаргал” хэмээхтэй шүтэлцүүлэн, зовлонгийн шалтгааныг заяа, нисванис /сэтгэлийн бузар/ хоёроор тайлбарласан байна. Ийнхүү хүний зовлонгийн шалтгаанаа танин мэдэж, өөрийгөө төгөлдөржүүлэх, дахин хүмүүжүүлэх зэрэг нь дунд төрөлхтөний явдал мөрийг эзэмшихийн үндэс болно.

Их төрөлхтөн гэдэг нь орчлонгийн амьдралыг ухаарч, нигүүсэхүй сэтгэлийн үүднээс хамаг амьтанд тус үйлдэгч ариун бодь сэтгэлтэй хүний хэв маяг юм. Их төрөлхтөн буюу дээд мэдлэгтний хэв маягт багтах хүн бол эш, онолоор /онол, практик / баялаг, бусдад нөлөөлөх чадвар бүхий хүний судлан ухаарах ёстой сэтгэлийн үндсийг дэлгэрүүлж үзье. Юуны өмнө сайн зарлигийн оньсыг танин барих сэтгэл үүсгэх ёсон ордог. Бурхны ёсонд хүний амьдралын эцсийн зорилт бол орчлонгийн зовлонгоос өөрийгөө ба бусдыг гэтэлгэх мөрд суралцаж сэтгэл үүсгэх явдал байдаг. Ийм учраас зарлигийн оньс буюу бурхны бодь сэтгэл эзэмшихүйг “бурхны номын хөрөнгө” гээд түүнд суралцах аргыг дараалан зааж өгдөг байна. Бодь сэтгэл нь их хөлгөнд суралцах, сэтгэл үүсгэх арга бөгөөд тэр нь амьтан бүхэнд тэгш сэтгэж, үнэн сэтгэлээс туслах буянт сэтгэлийн цогц болно. Их төрөлхтөн буюу дээд мэдлэгтний билигт хүрэх мөрийн үндсэнд явдалд суралцах мөр ордог. Энэ нь билгийн чанад хүргэх сэтгэлийн оньс 6 барамидад суралцана гэсэн хэрэг. Өглөг барамид - өөрийн биеийн хамаг хэргийг үл хайхран бусдын тусад үнэхээр зориулсан сэтгэлийн үр бөгөөд номын, аюулгүйн, эд таваарын өглөг хэмээн ялгаварлагдаж байхад, шагшаабад барамид - бусдыг хорлох шалтгааныг хааж, тэвчих сэтгэл бөгөөд дотроо санваар сахихын, буянт номын тус хүргэхүйн хэмээн тус тус ангилагддаг. Хүлцэнгүйн барамид – номын ёсонд бишрэн, бусдын тусыг хүлцэн биширч, хорлол бүхнийг тэвчих сэтгэлийн чадвар. Хичээнгүйн барамид- сэтгэлийг буяны зүг үнэхээр хандуулж бие, хэлээ түүнд зориулах сэтгэлийн чадавхи, харин дияан барамид- зорьсноос бусдад үл алгасан оршигч нэгэн үзүүрт сэтгэлийн зангилаа учир түүнд аглаг оронд суун, бие, сэтгэл, хэл гурваараа нэгэн зүгт чиглүүлэн бясалгаснаар хүрдэг. Билиг барамид – өмнөх барамидуудын манлай бөгөөд эрдэм ухааныг эзэмшин ухаарч, бусдад ачлал хүргэх гэгээрхүйн сэтгэл. Хүн гагцхүү дотоод сэтгэлээ төгөлдөржүүлэх, ухааныхаа билгийг хөгжүүлэх замаар үлэмж гэгээрэхүйд хүрэхүй ёсыг тодорхойлсон. Бодь сэтгэл үүсэх эдгээр аргад суралцахад “үлэмж хойт хоёр барамид” /амирлан ахуй, үлэмж үзэхүй/ онцгой ач холбогдолтой! “Амирлан оршихуй хэмээвээс нэгэн үзүүрт сэтгэл, үлэмж үзэхүй хэмээвээс үнэхээр өөрөө өөрийгөө ухаарахуй болно” хэмээснээс үзэхэд дияан хийгээд билиг барамидын ёс үндсийг нарийвчлан задалж, билигт хүрэх аргыг тодруулсан нь мөн болно¹⁰⁹ хэмээн үзжээ. Гурван төрөлхтөн бол гурван түвшний сэтгэлийн хөдөлгөөнтэй, хөөрөл, саатлын шүтэн барилдлагатай, аливааг тогтоох ой ухаантай, сэтгэхүйтэй, санаа бодолтой, санаа бодлоо илэрхийлэх үгсийн сантай, үйл явдалтай, амьдралтай, эрмэлзэл тэмүүлэлтэй, бясалгалтай, танин мэдэхүй хийгээд сэтгэлээ залж жолоодох чадвартай, сэтгэлийг ухаанжуулах, ухааныг сэтгэлжүүлэх бодит бололцоотой; тэдгээр чадвар, боломж, тэмүүлэл, амьдрал, үйл зэргийн хувьд шат дараалсан гурван түвшний гурван хэсэг бүлэг хүмүүс юм. Ер нь дээрх 3 бүлэг хүмүүс нь тус бүртгэн, дор дорoon, бас гурав, гурваар хуваагдаж, нийт .9. бүлэг болохоор байна.

Гэхдээ энэ хэсэгт буюу гурван төрөлхтний тухай сургаалтай уялдуулан хүмүүсийг сэтгэн бодох, ухааран ойлгох чадвараар нь 5 бүлэг болгон хуваасанд

¹⁰⁹ Гүн ухаан /Удиртгал/. УБ., 1999, 176 дах тал

анхаарлаа хандуулсан юм. Зураг №2-ын I-ээр тэмдэглэгдсэн хүмүүс дотроо дорд төрөлхтөн (1), бага төрөлхтөн (2); II-оор тэмдэглэгдсэн хүмүүс нь дотроо бага төрөлхтөн талруугаа хэлбийсэн дунд төрөлхтөн (а), тэнцвэрт тогтолцоот дунд төрөлхтөн (б), их төрөлхтөн тал руугаа хэлбийсэн дунд төрөлхтөн (в); III-аар тэмдэглэгдсэн бүлэг хүмүүс нь дотроо дээд төрөлхтөн (4), нэн дээд төрөлхтөн (5) гэж тус тус хуваагдана.

Дорны томоохон сэтгэгчийн нэг, эртний Хятадын нэрт соён гэгээрүүлэгч Күнз: "Хүмүүс уг чанараараа адил боловч, мэдлэг, ёс суртхууны байдлаар нилээд ялгаатай"¹⁰ хэмээн үзсэн бөгөөд нийгэм дэх хүмүүсийг мэдлэг боловсрол, ёс суртахуун хэмээх хоёр гол хүчин зүйлээр гурван үндсэн төрөлд хуваан үзжээ. Үүнд: Нэгдүгээрт, "Цюнь-Цзы" буюу "Эрхэм хүн", Хоёрдугаарт, "Жэнь" буюу "Дундаж хүн", Гуравдугаарт, "Сяо жэнь" буюу "Өчүүхэн хүн" эдгээр юм. Энэхүү хүний гурван төрлийн тухай Күнзийн үзэл баримтлал нь хүний оршихуйн үндэс бол ёс суртахуун, ялангуяа хүнлэг ёс хэмээн тайлбарладаг. Хүнлэг ёс нь нэг талаас хүний мөн чанарыг тодорхойлогч үндсэн гол шинж болдог, нөгөө талаас хүний оршихуйн үндэс, хүний зам мөрийг илэрхийлсэн өргөн агуулгатай байгаа нь монголын философи сэтгэлгээний мэдлэг ухааны дэвшилт өв сантай тохирч байдаг.

Гурван түвшний сургалт буюу орчин үе. Манай улсын нийгмийн амьдралын үндсэн хүрээнүүдийг хамарсан өөрчлөлт шинэчлэлт нь боловсролын салбарт хурдацтай явагдаж хүн бүр өөрийнхөө чадвар, сонирхлын дагуу суралцах эрх, эрх чөлөө нээлттэй болсон билээ. Өмчийн олон хэлбэрт тулгуурласан шат, шатны сургуулиуд борооны дараахь мөөг шиг олширч монголчууд бүгдээрээ дээд боловсролтой болох уралдаанд оролцох болсноор боловсролын хямрал улам гүнзгийрч байна. Өнөөгийн сургалтанд хүүхдийн оюун ухааны чадвар, төрөлх шинжийг үл харгалзан бүх сурагчдад нэгэн ижил зүйлийг заадаг, хавтгайруулсан сургалт олон жилийн туршид явагдсаар ирсэн. Үүний уршгаар бэлэн мэдээллээр тэжээгдсэн амьдрах арга ухаан, чадвар дутмаг, олон мэргэжилтэн төрж, өнөөгийн сургалт зарим талаар үр ашиггүй, сонирхолгүй, хэлбэрийн төдий үйл явц болон хувирсан. Энэ нь шавь төвтэй сургалт жинхэнэ мөн чанараараа хэрэгжихгүй бүхнийг тэгшлэн сургадаг сургалтын хуучин технологи үйлчилсээр байгаа гэсэн үг. Эзэмшүүлсэн мэргэжил, өндөр боловсрол давамгайлсан иргэдийн тоо жилээс жилд нэмэгдэж байгаа хэдий ч Зураг № 2-д тэмдэглэгдсэн ёсоор II-(а) буюу бага төрөлхтөн талруугаа хэлбийсэн дунд төрөлхтөн европын гүн ухааны хэлээр бол санамсаргүй нь зайлшгүйгээсээ, буддын гүн ухааны хэлээр бол арга нь билгээсээ давамгайлсан зүүн талын хэлбийлттэй тэнцвэрт бус тогтолцоотой сургалтын үе юм. Уг тогтолцооны үед суралцагсад нь өөрийнхөө сэтгэн бодох, ухааран ойлгох чадвараасаа хэт давсан сонголт хийснээр боловсрол эзэмшин мэргэжилтэй болсон ч тухайн мэргэжилтэнд тавигдаж буй шаардлагыг хангаж чадахгүйд хүрдэг.

Өнөө үед дээд боловсролтэй хүний тоо жилээс жилд өсч байгаа мөртлөө ажилгүйчүүдийн тоог нэмэгдүүлэх болсон түүхэн гашуун сургамж үүний тод илрэл болж байна. Энэ нь тухайн суралцагсад нь суралцах явцдаа савын буюу сонсохын гурван алдааг гаргаснаас үүдэлтэй гэж дүгнэж болно. Савын гурван гэмийг тэвчих талаар "Амыг хөмөрсөн сав (1), амыг дээш харуулсан ч хир буртагтай сав (2), хир буртаггүй хэдий ч ёроол нь цоорхой сав (3) байх аваас, тэдгээрт тэнгэрийн хур буувч сав дотор үл тогтох, тогтсон ч хир буртгаар бохирдсон тул уух тэргүүтний хэрэгцээ хангахгүй болох, хир буртгаар бохирлогдоогүй ч дотроо тогтохгүй савирч барагдахад хүрдэг. Түүнтэй адилаар,

¹⁰ Лунь-Юй. Древнекитайская философия. М., 1972. С. 139-174

ном сургуулийн хүрээнд суувч чихээ үл тавих (1) (үл сонсох), тавьсан ч буруугаар барих юм уу язгуур сэтгэл нь гэмтэй байх (2), эдгээр гэмүүд байхгүй ч сонсохын цагт үг, утга зэргийг баттай барилгүй мартах зэргээр доройтуулбаас (3) ном сонсох, сурахын их тус гарахгүй тул тэдгээрийг орхих хэрэгтэй”¹¹¹ гэж сургасан байдаг.

Дээрх сургаал ёсоор суралцагч шавь нь зорилго тавин сургуульд сурахаар суусан хэдий ч, хэрэв багшийн заасныг анхааралтай эс сонсвоос, сонссон чиг гэсэн утга агуулгыг буруугаар ойлговоос, эсвэл буруу санаа бодлыг агуулан сонсвоос; эсвэл дээрх гурван чигийн алдаа гаргахгүй байлаа гэхэд сонссон сурснаа эс тогтоовоос, тогтоосон чиг тэр дороо мартваас, мартаагүй чиг гэсэн түүндээ ач холбогдол эс өгвөөс мэргэжил эзэмшин сургууль төгссөний хэрэг гарахгүй. Тийм болохоор савын гурван гэмийг, сонсохын гурван алдааг гаргахгүй байх ухаанд суралцах хэрэгтэй. Энэ тухай “Их бодь мөрийн зэрэг”-т: “Бүхнийг мэдэж авахын тулд анхаарлаа дээд зэргээр төвлөрүүлэн, сэтгэлээ дээд зэргээр гарган, бодлоо дээд зэргээр дайчлан сонсох хэрэгтэй”¹¹² хэмээн сургасан байна. Буддын сурган Винай (номхотгол)-н ёсонд сурах аргыг заан:

- Олоогүй эрдмээ олон үйлдэх арга

- Олсноо үл бууруулах арга

- Буурснаа жич засах аргаар тодорхойлон түүнийг ухаан боловсрох (оньс) гэж сургажээ. Ном сонсох шавийн ёсыг “савын гурван гэм”-ийг тэвчин “Зургаан хуран мэдэхүйг шүтэх” дэг журмаар гүйцэтгүүлж, ном хийгээд ном өгүүлэгч (багш)-ийг хүндэтгэх ёсонд сургаж байсан¹¹³. Уг сургаал нь орчин үед ч суралцагсадад тавигдах нийтлэг, түгээмэл шаардлагатай тохирч байгаа ч шавь нарын сэтгэлийг төлөвшүүлэх талаар өрнөдийн сурган учир дутагдалтай гэдгийг хүлээн зөвшөөрөх байхаа. XXI зуунд монголчууд бидний хувьд зураг №2-оор тэмдэглэгдсэнээр 3 (б) тэнцвэрт тогтолцоот дунд төрөлхтнөөс 3 (в) их төрөлхтөн тал руугаа хэлбийсэн дунд төрөлхтөн рүү ихэнх нь, 4 дээд, 5 нэн дээд төрөлхтөн рүү цөөнх нь хүрэх сургалт явуулах зайлшгүй шаардлага тавигдаж байна.

Энэхүү түүхэн шаардлагыг хэрэгжүүлэх арга зам нь буддын сурганы онолын хүрээнд өрнөдийн сурганы онол сургаал шингэн синтезлэгдэх, түүний үр дүнд сурган хүмүүжүүлэх шинэ, онол сургаал бий болж хэрэгжих учиртай. Иймд одоо хэрэгжиж байгаа шавь төвтэй сургалтын технологийг хэрэгжүүлэхдээ монгол хүн бүрийн гарваль шинж, төрөлхийн онцлогт тохирсон сургалтыг монголын уламжлалт “савыг” үзэн сургадаг буддын сурганы арга билгийн сэтгэлгээтэй шүтэлцүүлэн явуулж чадсанаар нийгмийн чадвар бүхий “дэлхийн иргэд”-ийг жинхэнэ ёсоор төрүүлэн гаргах болно. Сургалтын явцад шавь нар ном эрдэм сурах ажилд өөрийн бүхий л оюун ухаан, сэтгэл санаа, биеийнхээ эрч хүч энергийг дээд зэргээр дайчлан суралцах чадвар эзэмшинэ. Энэ үед сургалтын түвшин бүрт тохирсон багш, шавийн шинж харьцааны зохистой байдал төлөвших зүй тогтолтой. Ийнхүү боловсролын хүн төвт болон нийгэм төвт номлолыг зохистой хослон хөгжүүлэх нөхцөл бүрдэнэ.

¹¹¹ Зонхава Лувсандагва. Их бодь мөрийн зэрэг. / Төвд хэлнээс орчуулсан Т.Булган / . УБ., 2004. 22 дахь тал

¹¹² Чже цонкапа. Большое руководство к этапам пути пробуждения. Т.1, СПб., 1994, 38 дахь тал

¹¹³ Г.Эрдэнэ-Очир. Хүнээр хүн хийх монгол ухааны сурвалж. УБ., 1991. 141 дэх тал

Ном зүй

1. Адиша. Бодь мөрийн зул. М.Д.183 боть. 3 дээд
2. Гүн ухаан /удиртгал/. УБ. 1999
3. Зонхава Лувсандагва. Их бодь мөрийн зэрэг /Төвд хэлнээс орчуулсан Т.Булган/ УБ. 2004
4. Лунь- Юй. Древнекитайская философия. М. 1972
5. Монголын дээд боловсрол: ХХI зууны үзэл баримтлал. (Эрдэм шинжилгээний бага хурал). УБ.1999
6. Тейяр-де-Шарден. Феномен человека. М. 1957
7. Цонкапа Чже. Большое руководство к этапам пути пробуждения.V, СПб,2000
8. Эрдэнэ-Очир Г. Хүнээр хүн хийх монгол ухааны сурвалж. УБ. 1991
9. Эрх чөлөө ба философи. I. УБ. 1998